



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/04

Булган сум

“Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV дүгээр хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Б.Юмжирмаа (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч)
	М.Солонго (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Б.Мөнхгэрэл (Боловсролын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Л.Одгэрэл (Боловсролын газрын Гадаад хэлний боловсрол хариуцсан ахлах арга зүйч)
	Э.Түвшинмөнх (Ерөнхий боловсролын I сургуулийн захирал)
	Ж.Маралмаа (Булган сумын Соёлын ордны Номын санч)
Нарийн бичгийн дарга:	М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2. “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж, 2025 оны I улиралд батлуулахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010124